



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

ХХХХ оны ХХ сарын ХХ өдөр

Дугаар 10

Мандалговь

Г

Б.Буманбаатарыг Газрын харилцаа, барилга,
хот байгуулалтын газрын Хот байгуулалтын кадастр,
зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан
мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогох ажилтны сонгон шалгаруулалтад Батсайханы Буманбаатар 66.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Буманбаатарын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ш.ТӨРБАТ

Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2022 оны 10-дугаар сарын
22-ны өдрийн 10-дугаар тогтоолын хавсралт



**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Хот байгуулалтын
кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтний
албан тушаалд нэр дэвшүүлсэн Б.Буманбаатарын тухай дүгнэлт**

1. Б.Буманбаатар нь 1998 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 24 настай, эрэгтэй
2. Боловсрол: 2017-2021 онд Шинжлэх ухаан техникийн их сургуулийг архитекторч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Б.Буманбаатарын тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ